



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/318

Мөрөн сум

Барилга байгууламж хүлээж авах комисс  
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, 48.6 Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжсэн Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын 150 ортой цэцэрлэгийн барилга байгууламжийг хүлээж авах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)

М.Анхбаяр (Барилгын хөгжлийн төвийн Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хяналтын инженер) зөвшилцсөнөөр

Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Д.Мягмарсүрэн (Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Барилга техник хяналтын улсын байцаагч)

Д.Аюушжав (Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Барилга техник хяналтын улсын байцаагч)

Ж.Нацагдорж (Аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын байцаагч)

Д.Сүхээ (Хөвсгөл Ус суваг ХХК-ийн Ерөнхий инженер)

Б.Аюуш (Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн Ашиглалтын албаны дарга)

Ц.Ганзориг (Боловсрол шинжлэх ухааны газрын дарга)

Н.Далайжаргал (Боловсрол шинжлэх ухааны газрын Ахлах мэргэжилтэн)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

А.Ичинхорлоо ("Өлзий иш" ХХК-ийн Захирал)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Б.Батхишигт ("Мөнх-Өргөө" ХХК-ийн Захирал)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Х.Ганболд (Бүрэнтогтох сумын Засаг даргын Тамгын газрын дарга)

Э.Дариймаа (Бүрэнтогтох сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч)

Ё.Баяржавхлан (Бүрэнтогтох сумын Хүүхдийн цэцэрлэгийн нягтлан бодогч)  
Н.Цогтсайхан (Бүрэнтогтох сумын Байгаль хамгаалагч)  
Х.Лхагвадорж (Бүрэнтогтох сумын цахилгааны монтёр)  
Х.Оролмаа ("Идэрнумт" ХХК-ийн механик)  
Ж.Пүрэвжал (Бүрэнтогтох сумын иргэний төлөөлөл)

Комиссын нарийн бичгийн дарга:

Б.Баасанжав (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Барилга байгууламж хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилга байгууламж хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Баасанжав) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилгын ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Барилга байгууламжийн ажлыг хүлээн авсан тухай мэдээллийг олон нийтэд сурталчилж, мэдээ мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

6. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН